

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН**

2026 оны 01 дугаар сарын 15-ны өдөр

1.ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Төсвийн тухай хууль, дотоод аудитын дүрмийг баримтлан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, худалдан авах ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавих, төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, эрсдэлийн удирдлагаар хангах, дүгнэлт зөвлөмж боловсруулж үр дүнг тайлагнах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллалаа.

Тус газар нь Монгол улсын Засгийн газрын 2025 оны Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай 07 дугаар тогтоол, АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/42-р тушаалаар 18 албан хаагчийн бүтэц орон тоотойгоор батлагдан ХШҮДАГ-ын даргаар Ц.Өнөрнасан, ахлах шинжээч И.Баттуяа, Д.Батнайрамдал, шинжээч Ц.Тэмүүжин, ахлах мэргэжилтэн Б.Баттуул, мэргэжилтэн Г.Батчимэг, Салбарын хяналтын хэлтсийн 12 улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

- ❖ Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Дотоод аудитын төлөвлөгөө батлах тухай” А/28 дугаар тушаалын дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаар дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын хамтарсан-3, нийт 3 дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн байна.
- ❖ “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тус газрын хэрэгжүүлэх нийт 2 зорилтын 35 арга хэмжээг баталсан. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын хүрээнд, батлагдсан төсөвт багтаан зохион байгуулан ажилласан.

2.САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газрын 2025 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн

сайдын 2022 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-аар зохицуулагдах Геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлын хэрэгжилтэд дотоод аудитыг хийж гүйцэтгээд байна.

Аудитаар зэрэг аргачлал хяналтын зардал дансны төлөвлөлт, хөрөнгийн зарцуулалтад дотоод аудитыг гүйцэтгэж, дүгнэлт зөвлөмжийг гаргаж, шалгалтын ажлын тайланг удирдлагуудад танилцуулан Үндэсний геологийн албанд 01/2669 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дотоод аудит хийж, дотоод аудитын тайланг яамны удирдлагуудад танилцуулсан.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, “Төсвийн тухай” хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын хүрээнд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

3. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/56 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Ашигт малтмал, газрын тосны газар”, “Үндэсний Геологийн алба”, “Геологийн судалгаа шинжилгээний төв” ТӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэн, дотоод аудитын тайланг удирдлагад танилцуулж харьяа байгууллагуудад аудитын тайланг 01/1051 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.
4. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/214 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг “Цөмийн энергийн комиссын ажлын алба”-ны 2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэн, дотоод аудитын тайланг удирдлагад танилцуулагдсан.
5. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дотоод аудитын тайланг яамны удирдлагуудад танилцуулсан.

“Төсвийн тухай” хууль, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомжийн хүрээнд дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

Үндэсний аудитын газраас 2024 онд сайдын багцад хийсэн санхүүгийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитын хүрээнд гарсан зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллахаар эрчимжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хянах, гүйцэтгэлийн талаар хариу хүргүүлэх ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа геологийн судалгааны төслүүдийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудитын 2024/21-ШТА-ГА тайлан, дүгнэлт зөвлөмжид

үндэслэн гаргасан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт тавин ажиллаж байна.

2. “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын баталгаажуулалт”-д хийсэн СНАГ-2024/02-НА-НА аудитын тайланд үндэслэн гаргасан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт тавин ажиллаж байна.

3. Яамны болон сайдын багцын 2024 оны санхүүгийн тайланд аудит хийж байсантай холбогдуулан шаардлагатай баримт материалуудыг гаргаж, нотлох баримтуудын бүрдлийг хангаж, холбогдох тайлбаруудыг хийсэн. Түүнчлэн аудитын тайлантай танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Үндэсний аудитын газраас 2025 онд “Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт”, “Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт”, “Үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн шилжилтийн үйл явц, үр дүн”, “Уул уурхайн тусгай зөвшөөрлийн олголт, хууль тогтоомжийн хэрэгжилт”, “Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө”, “Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл тусламжийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөө”-д тус тус аудит хийхээр ирсэн ажлын хэсэгт шаардлагатай мэдээллүүдийг боловсруулж хүргүүлэх, нотлох баримт бүрдүүлэх, тайлбар хийх зэргээр хамтран ажилласан.

3.БУСАД ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу хөгжлийн бодлого, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хуулийн хугацаанд буюу сар, улирал, жилээр гүйцэтгэлийг хянаж, Засгийн газрын unelgee.gov.mn, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны mmhi.gov.mn цахим хуудсанд үнэлгээний тайланг байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.

Салбарын хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инновац, шинэ технологийг ил тод байдлыг хангах зорилгоор Ухаалаг засаглал ТББ-тай хамтран “Хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний программыг нэвтрүүлэн бодлогын баримт бичгийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг цахимаар хүлээн авч ажилласан. Цаашид 2026 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг “Хяналт-шинжилгээ”-ний цахим программаар хүлээн авч тайлагнах бэлтгэл ажлыг хангаж байна.

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/192 дугаар тушаалаар байгуулагдсан “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын гомдлыг хянах үүрэг бүхий” Ажлын хэсгийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн гомдлыг тухай бүр хянаж шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэлгээ хийх журам”-ын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2026 оны үнэлгээ хийх төлөвлөгөөг батлуулан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР